



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
VIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 17-ны өдөр

Дугаар VIII/07

Булган сум

Сумын газар зохион байгуулалтын  
2021 оны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж,  
2022 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган сумын Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний биелэлтийг ХАНГАЛТТАЙ гэж үнэлсүгэй.

2.Булган сумын Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөг 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 хавсралтаар тус тус баталсугай.

3.Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэхийг, Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах ажлыг шуурхай зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

4.Сумын тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахаар санал оруулсан (хавсралт 4-д заасан) Булган сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байршилтай 10 га газрыг Булган сумын ЗДТГ-т эзэмшүүлж, Газрын тухай хуулийн 33.1.1-д заасны дагуу төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх заалтын хүрээнд гэрээ байгуулж, хэрэгжилтийг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар дүгнүүлж байхыг сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д даалгасугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хөдөөгийн асуудал эрхэлсэн Хорооны дарга, гишүүдэд хариуцуулсугай.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ

